



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 11/103

Чойр

Хагас жилийн малын түүвэр судалгаа болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, зардлын судалгаа явуулах тухай

Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн в, л заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хагас жилийн малын түүвэр судалгаа болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, зардлын судалгааг 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 22-ны өдрүүдэд орон нутагт зохион байгуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

КОМИССЫН ДАРГА:

Б.БАТДЭЛГЭР- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Я.ОТГОНБАЯР- Улсын бүртгэл, статистикийн газрын Статистикийн хэлтсийн дарга

ГИШҮҮД:

Ш.ДАРХАНБАТ- Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга


Г.УРАНЧИМЭГ- Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Д.АРИУНАА- Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Х.МӨНХЖАРГАЛ- Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын дарга

2. Судалгаа явуулахтай холбогдуулан түүврээр сонгогдсон өрхийг тооллогод бүрэн хамруулах арга хэмжээ авч, тооллогын ажлыг удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр ханган, хугацаанд нь багтаан явуулахыг комиссын дарга /Б.Батдэлгэр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Л.ОДСЭР

02 0537